



Иргэний нисэхийн үндэсний төв  
Нисэхийн сургалтын төв



# ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАН ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын код: НСТХ-5414-11-М-04

Суралцах хугацаа: 16 цаг


## ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ДАРААХ ХЭСГЭЭС БҮРДЭНЭ

- I. СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА
- II. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ
- III. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН БҮТЭЦ
  - Чадамжийн нэгжийн нэр, код, тодорхойлолт, өмнө нь эзэмшсэн байвал зохих чадамжийн нэгж
  - Чадамжийн нэгжийн агуулгын төлөвлөлт
  - Гүйцэтгэлийн цар хүрээ, нөхцөл
  - Чадамжийн элементийн төлөвлөгөө
- IV. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА
  - Суралцагч
  - Багш
  - Сургалтын орчин
- V. ҮНЭЛГЭЭНИЙ УДИРДАМЖ
  - Үнэлгээний төлөвлөгөө
- VI. ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- ГШҮ - Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
- НСТ - Нисэхийн сургалтын төв
- НСТЖ-09 – Нисэхийн сургалтын төвийн сургалтын хөтөлбөр боловсруулах журам
- ХХБҮ – Хөндлөнгийн хууль бус үйлдэл
- ХАБЭА – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- ЧН - Чадамжийн нэгж
- ЧЭ - Чадамжийн элемент
- CBS - Гар тээш
- DGR – Dangerous Goods Regulations
- HBS - Бүртгэгдсэн тээш
- IATA – International air transport association
- Simfox - Рентген дадлагажуурын программ хангамж
- X-Ray - Рентген туяа



## I. СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

**Хөтөлбөрийн нэр:** Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх.

**Сургалтын нийт цаг:** Нийт 16 цаг (Онол 4 цаг, дадлага 11 цаг, шалгалт 1 цаг).

**Хөтөлбөрийн үндэслэл:** Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын 2.1.6 (Энэ журмын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий болон бусад оролцогч байгууллагуудын ажилтныг бэлтгэх сургалтын бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжилтийг эдгээр байгууллагаас шаардах), Иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын нэгдсэн хөтөлбөрийн 6.4.1 дэх (Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын дагуу нисэхийн аюулгүй байдлын үүрэг, хариуцлага хүлээхээр заагдсан цагдаа, тагнуул, хил хамгаалах болон хилийн хяналт, шалгалтын байгууллагууд нь тус журмыг хэрэгжүүлж ажиллахын тулд нисэхийн аюулгүй байдлын мэдлэгтэй байх шаардлагатай.) заалтыг тус тус үндэслэн энэхүү сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

**Хөтөлбөрийн зорилго:** Хилийн хяналт, шалгалтын байгууллага болон Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан, албан хаагч нарт тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх, хязгаарласан, хориглосон эд зүйлсийг илрүүлэх, рентген дүрсийг тайлж унших арга аргачлалын анхан шатны мэдлэг олгоход оршино.

**Хөтөлбөрийн зорилт:** Энэхүү сургалтад хамрагдсанаар дараах сэдвийн хүрээнд мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ. Үүнд:

- Тоног төхөөрөмжийн талаарх ойлголт;
- Рентген туяаны аппарат ашиглан үзлэг хийх;
- Рентген дүрс тайлж унших;
- Хязгаарласан, хориглосон эд зүйлсийг таних.

**Хүрэх үр дүн:** Үзлэгийн тоног төхөөрөмжийг стандарт зааварчилгааны дагуу ашиглах анхан шатны мэдлэгтэй болсон байна.

## II. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Чадамжийн нэгжийн нэр	Код
1	Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх	НСТХ-5414-11-М-04

## III. ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН БҮТЭЦ

<b>Чадамжийн нэгжийн нэр:</b> Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх
<b>Чадамжийн нэгжийн код:</b> НСТХ-5414-11-М-04

<b>Чадамжийн нэгжийн тодорхойлолт:</b> Хязгаарласан хориглосон эд зүйлсийг таньж илрүүлэх, үзлэг шалгалт хийхэд шаардлагатай мэдлэг олгоход оршино.
<b>Өмнө нь эзэмшсэн байвал зохих чадамжийн нэгж:</b> -

### Чадамжийн нэгжийн агуулгын төлөвлөлт:

№	Чадамжийн элемент	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Анги дүүргэлт: 15-20		
			Чадамжийн нэгжид ноогдох цаг: 15		
			Онол	Дадлага	Чадамжийн элементэд ногдох цаг
1	ЧЭ 1: Үзлэг шалгалт хийх	ГШҮ 1.1 Тоног төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг шалгалт хийх, рентген дүрсийг тайлж унших	2		15
		ГШҮ 1.2 Зан байдлыг таньж тогтоохоор ажиглалт хийх	1		
		ГШҮ 1.3 Simfox дадлагажуурын программ дээр дадлага хийх	1	11	
Шалгалт					1
Цагийн харьцаа			4	11	16
Онол, дадлагын харьцаа			30:70		

**Гүйцэтгэлийн цар хүрээ, нөхцөл:**

Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журам	- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам; - Дадлагажуурын тоног төхөөрөмжтэй ажиллах зааварчилгаа.
Ажил гүйцэтгэх зааварчилгаа	- Simfox тоног төхөөрөмжийн гарын авлага.
Ажлын хүрээнд хамтран ажиллах хүмүүс	- Үзлэгийн цэгээр нэвтэрч буй ажилтан, албан хаагч, иргэн, зорчигч.
Орчин нөхцөл	- Хэвийн.

**ЧАДАМЖИЙН ЭЛЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 1**

<b>Чадамжийн нэгжийн нэр:</b>	Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх.
<b>Чадамжийн элемент 1-ийн нэр:</b>	Үзлэг шалгалт хийх.
<b>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт:</b>	ГШҮ 1.1 Тоног төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг шалгалт хийх, рентген дүрсийг тайлж унших; ГШҮ 1.2 Зан байдлыг таньж тогтоохоор ажиглалт хийх; ГШҮ 1.3 Simfox дадлагажуурын программ дээр дадлага хийх.
<b>Чадамжийн элементэд ногдох цаг:</b>	Онол 4 цаг, дадлага 11 цаг.
<b>Эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага:</b>	<p><b>Мэдлэг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үзлэгийн тоног төхөөрөмж;</li> <li>- Ажиглалт тандалт;</li> <li>- Хязгаарласан, хориглосон эд зүйлсийг таних;</li> <li>- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэглэлийг таних;</li> <li>- Сум, галт хэрэглэлийг таних;</li> <li>- Бусад аюултай эд зүйлсийг илрүүлэх.</li> </ul> <p><b>Ур чадвар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үзлэгийг тоног төхөөрөмж ашиглан хийх;</li> <li>- Рентген дүрсийг унших, дүгнэх;</li> <li>- Рентген дүрснээс аюултай, хориотой эд зүйлсийг илрүүлэх;</li> <li>- Дүрс дүгнэх үйлдлийг хийж гүйцэтгэх;</li> <li>- Хязгаарласан хориглосон эд зүйлсийг мэдэх.</li> </ul> <p><b>Хандлага:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багаар ажиллах;</li> <li>- Харьцааны соёлтой байх;</li> <li>- Ажигч гярхай байх;</li> <li>- Нууцлалыг хадгалах;</li> <li>- Хариуцлагатай байх;</li> <li>- Аюулгүй ажиллагааг мөрдөх.</li> </ul>

Сургалт явагдах орчин:	Нисэхийн сургалтын төв.
Сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт:	<ul style="list-style-type: none"> <li>- Simfox дадлагажуурын тоног төхөөрөмж;</li> <li>- Самбар, маркер, проектор, дэлгэц;</li> <li>- Видео бичлэг.</li> </ul>
Материал, түүхий эдийн жагсаалт:	Шаардлагагүй.
Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт:	Шаардлагагүй.
Ашигласан материал:	IATA DGR, edition 65, 2024.

#### IV. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА

Суралцагчид тавих шаардлага:

- Хилийн хяналтын байгууллагын ажилтан байх;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан байх;
- Тухайн байгууллагаас албан хүсэлт ирүүлсэн байх.

Багшид тавих шаардлага:

Нийтлэг шаардлага:

- НСТ-ийн УАЕЗ-ын 2.6 "Нисэхийн сургалтын төвд сургалт явуулах, шалгалт авах хүмүүсийн боловсрол, мэргэжлийн ур чадварын түвшинд тавигдах шаардлага" заалтад тавьсан шаардлагуудыг хангасан байх.

Сургалтын орчин: Сургалтын онолын танхим, ухаалаг самбар, дадлагажуур.

Сургалтын тоног төхөөрөмж багаж хэрэгслийн жагсаалт:

Маягт 1

№	Сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн үзүүлэлт, тодорхойлолт
1	Дадлагажуурын /simfox/ программ хангамж	ширхэг	6	<ul style="list-style-type: none"> <li>- Багш, сурагч компьютер нь дотоод сүлжээ /LAN/-ээр холбогддог байх</li> <li>- Интернэттэй холбогдсон байх</li> <li>- Customisable – тохируулах боломжтой</li> <li>- Flexible – хувирах чадвартай</li> <li>- Comprehensive – цогц</li> <li>- Attractive design – үзэмж сайтай</li> <li>- Generate your own lessons – хичээл боловсруулах боломжтой</li> <li>- Ability to continually update your - database – мэдээллийн санг баяжуулах боломжтой</li> </ul>

					- Online capabilities – цахимаар холбогдоно - Image enhancements – дүрс тодруулах боломжтой
2	Металл илрүүлэгч гар багаж	ширхэг	1	PD140N	

**Сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт:**

Маягт 2

№	Сургалтын хэрэглэгдэхүүний нэр	Тоо ширхэг
1	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр	1
2	Зэвсэг, тусгай хэрэгсэл, хориглосон эд зүйлсийн биет үзүүлэн	1 ком

**V. ҮНЭЛГЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Үнэлгээний зорилго:**

Суралцагч тухайн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай онол, дадлагын мэдлэг, ур чадвар, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны технологи, техник тоног төхөөрөмжийн ашиглалт болон аюулгүй ажиллагааны зааварчилгааны талаар анхан шатны ойлголттой болсон эсэхийг үнэлэх.

**Үнэлгээний зохион байгуулалт:**

- Нийт ирцийн 90%-ийн ирцийг хангаагүй тохиолдолд үнэлгээний шалгалтад хамруулахгүй;
- Үнэлгээний шалгалтад 80%-иас дээш авсан тохиолдолд тэнцэнд тооцно;
- Үнэлгээний шалгалт 80%-иас доош авсан тохиолдолд НСТ-ийн ҮАЕЗ-ын дагуу давтан шалгалтад хамруулна;
- Үнэлгээний шалгалтыг тест асуулт хэлбэрээр бичгээр эсхүл цахимаар зохион байгуулна.

**Үнэлгээний орчин:**

Үнэлгээ хийх танхим, шалгалтын материал (тест), интернэтийн сүлжээнд холбогдсон компьютер бэлтгэнэ.

**Суралцагчид тавих шаардлага:**

- Чадамжийн нэгжийн агуулгыг бүрэн судалсан байх;
- Суралцагч нь тухайн сургалтад бүрэн хамрагдах үүрэгтэй.

Суралцагчийн мэдлэг, ур чадварыг үнэлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Шалгалтын материал нууцлалтай байх;
- Үнэлгээ шударга, бодитой байх;
- Суралцагчийн үнэлгээ нууцлалтай байх.




Үнэлгээний хэрэгсэл №1: Тест

Чадамжийн элемент	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Асуулт	Зөв хариулт
ЧЭ 1: Үзлэг шалгалт хийх	ГШҮ 1.1 Тоног төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг шалгалт хийх, рентген дүрсийг тайлж унших	Гар тээшийг хэдэн градусын өнцгөөр байрлуулбал зөв харагдах вэ? A. 90° B. 180° C. 45° D. 360°	C
	ГШҮ 1.3 Simfox дадлагажуурын программ дээр дадлага хийх	Органик материалууд өнгөт дэлгэц дээр ямар өнгөөр харагдах вэ? A. Ногоон B. Улбар шар C. Хөх D. Хар	B
		Өнгөт дэлгэц дээрх хөх өнгийн дүрс нь ямар элементийг илэрхийлэх вэ? A. Атом жин нь 11-18 хоорондох B. Атом жин нь 11-с бага C. Атом жин нь 18-с их D. Аль нь ч биш	C
		Өнгөт дэлгэц дээрх дүрсийн өнгө нь юуг илэрхийлэх вэ? A. Материалын зузаан нимгэнийг B. Материалын төрлийг C. Материалын нягтыг	B
		Органик зүйлийг ямар товчлуураар тодруулж харах вэ? A. O2 B. OS C. SEN D. IM	A
		NEG функцийг ашигласнаар: A. Шингээлт ихтэй зүйлийг хараар, багатай зүйлийг цагаанаар харуулна B. Шингээлт ихтэй нь цагаан, багатай нь хар харагдана C. Органик бодис хараар, бусад нь цагаан харагдана D. Органик бус бодис цагаан, бусад нь хараар харагдана	B
		Тэсрэх төхөөрөмж? A. Ammunition B. Explosive Device C. Stunning device	B
		Иргүй мохоо багаж? A. Workmen's Tools	C

		B. Sharps C. Blunt instruments	
		Галт зэвсгийн бүрэлдэхүүн хэсэг? A. Dangerous goods B. Firearm components C. Liquids	B
		Хориглосон эд зүйлсэд хүүхдийн тоглоомын буу хамаарах уу? A. Тийм B. Үгүй	A

Ерөнхий үнэлгээ: Онолын мэдлэгийг бататгах нийт 10 асуулттай байна. Рентген дадлагажуурын программ дээр суралцагч тус бүрээс гар тээш, тээш, ачаа шуудангийн рентген дүрс бүхий тестийн шалгалт авна. Нийт 80%-аас дээш оноо авсан тохиолдолд "Чадамжтай" гэж тооцно.



## ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сургалтын төрөл:	Мэдлэг олгох	Чадамжийн нэгжийн код:	НСТХ-5414-11-М-04
Чадамжийн нэгжийн нэр	Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх	Үнэлгээний төлөвлөгөөний хувилбарын дугаар	01

Чадамжийн элементийн нэр	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн нотолгоо	Үнэлгээ хийх орчин	Үнэлгээний арга, хэрэгсэл
ЧЭ: Үзлэг шалгалт хийх	<p>ГШҮ 1.1 Тоног төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг шалгалт хийх, рентген дүрсийг тайлж унших</p>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгааны талаар анхан шатны мэдлэгтэй болж үзлэгийн үйл ажиллагаандаа ашиглах чадвартай болсон байна.</li> <li>✓ Хязгаарласан хориглосон эд зүйлсийн рентген дүрсийг таньж илрүүлэх анхан шатны мэдлэгтэй болсон байна.</li> <li>✓ Үзлэг шалгалтын бусад тоног төхөөрөмжийн талаар мэдлэгтэй болсон байна.</li> </ul>	Нисэхийн сургалтын төв, simfox дадлагажуурын өрөө	Бичгийн арга, дадлага
	<p>ГШҮ 1.2 Зан байдлыг таньж тогтоохоор ажиглалт хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэмт этгээдийн биеийн хэл, Дохио зангаа зэрэг зан байдлын хэвийн бус шинжийг ажиглан илрүүлэх анхан шатны мэдлэгтэй болсон байна.</li> </ul>		
	<p>ГШҮ 1.3 Simfox дадлагажуурын программ дээр дадлага хийх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хязгаарласан хориглосон эд зүйлсийн рентген дүрсүүдтэй танилцсан байна.</li> <li>✓ Бусад эд зүйлсийн рентген дүрсүүдтэй танилцсан байна.</li> <li>✓ Рентген дүрс бүхий стандарт тест дээр ажиллаж ялгаатай дүрсийг таних анхан шатны чадвартай болсон байна.</li> </ul>		

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ № 1

№	Үе шат	Багшийн ажиллагаа	Суралцагчийн үйл ажиллагаа	Хугацаа	Анхаарах зүйлс
1	Зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>✓ Мэндлэх, хичээлийн үед баримтлах зарчим болон мөрдөх ХАБЭА дүрмийг хэлэх;</li> <li>✓ Сургалтын гол агуулга, зорилго, хүрэх үр дүнгийн талаар танилцуулах;</li> <li>✓ Төгсөлтийн үнэлгээг хэрхэн хийх талаар танилцуулах.</li> </ul> <p>Тоног төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг шалгалт хийх; рентген дүрсийг тайлж унших дараах мэдлэгийг өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Давхардсан дүрсийг ялгах, ялгаатай атом жинтэй бодисууд давхардсан үед өнгөний өөрчлөлтийг салгах, шинэ технологи танилцуулах;</li> <li>✓ Үелэх систем дээр ялгаатай атом жингээр тайлбарлах;</li> <li>✓ Өнгөт дэлгэцэн дээрх дүрсийн өнгө болон өнгөний цайруулалт юуг илэрхийлэхийг тайлбарлах;</li> <li>✓ Хязгаарласан хориглосон эд зүйлсийн рентген дүрсийг тайлбарлах;</li> <li>✓ Ялгаатай рентген дүрсийг тайлж уншихад ашиглах дүрс дүгнэх товчлууруудыг тайлбарлах;</li> <li>✓ Ажиглах чадварыг дээшлүүлэх зорилгоор зураг үзүүлэх, сонирхлыг татах, рентген зурган тест авах.</li> </ul>	<p>Суралцах ажиллагаатай танилцаж, хичээлийн үед баримтлах зарчим, ХАБЭА-н дүрмээ хангах</p>	10 мин	
2	Шинэ мэдлэг эзэмшүүлэх ПШ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>✓ Зан байдлыг таньж тогтоохоор ажиглалт хийх дараах аргачлалыг тайлбарлана. Үүнд:</li> <li>✓ Сэжигтэй эд зүйл болон зорчигчийн үйл хөдлөл зан байдлаар илрүүлэх аргачлал;</li> <li>✓ Сэтгэл зүйн уялдаа бүхий арга барил;</li> <li>✓ Хүний гадаад төрх, ярианы ба ярианы бус хэл, биеийн хэл, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал зэрэг шинж тэмдэгт тулгуурлан дүн шинжилгээ хийх;</li> <li>✓ Дүгнэлт хийсний үндсэн дээр хүний зан байдлыг урьдчилан таамаглах;</li> <li>✓ Цогцолбор арга хэмжээг бодит жишээ дээр тайлбарлах;</li> </ul>	<p>Анхааралтай хандаж идэвхтэй оролцох</p>	90 мин	<p>Суралцагчдад хоорондоо ярих, сэдвээс өөр зүйл ярьж цаг үрэхгүй байх.</p>
3	Шинэ мэдлэг эзэмшүүлэх ПШ 1.2	<ul style="list-style-type: none"> <li>✓ Зан байдлыг таньж тогтоохоор ажиглалт хийх дараах аргачлалыг тайлбарлана. Үүнд:</li> <li>✓ Сэжигтэй эд зүйл болон зорчигчийн үйл хөдлөл зан байдлаар илрүүлэх аргачлал;</li> <li>✓ Сэтгэл зүйн уялдаа бүхий арга барил;</li> <li>✓ Хүний гадаад төрх, ярианы ба ярианы бус хэл, биеийн хэл, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал зэрэг шинж тэмдэгт тулгуурлан дүн шинжилгээ хийх;</li> <li>✓ Дүгнэлт хийсний үндсэн дээр хүний зан байдлыг урьдчилан таамаглах;</li> <li>✓ Цогцолбор арга хэмжээг бодит жишээ дээр тайлбарлах;</li> </ul>	<p>Анхааралтай хандаж идэвхтэй оролцох</p>	20 мин	

	<ul style="list-style-type: none"> <li>✓ Нисэх буудлын барилга байгууламж, агаарын хөлөгт алан хядах үйл ажиллагаа явуулахаар завдаж буй зорчигчдыг таних;</li> <li>✓ Нуугдмал галт ба хүйтэн зэвсэг болон тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх;</li> <li>✓ Сэтгэл зүйн хувьд тогтворгүй зорчигчдыг хэв журмын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх;</li> <li>✓ Нисэхийн профайлын гол агуулга нь зорчигч болгон алан хядагч, бүх эд зүйлийг зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис болгон ашиглах.</li> </ul>		25 мин	
	<p>Суралцагчдыг 2-3 хүний бүрэлдэхүүнтэй баг болгон хуваарилна. Simfox дэдлагажуур дээр ажиллуулна.</p> <p>Simfox дэдлагажуурын программ дээр дадлага хийх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Рентген туяаны төхөөрөмжийн бүтэц зохион байгуулалтыг танилцуулах;</li> <li>✓ Рентген туяаны төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгааг хэлэх;</li> <li>✓ CBS- гар тээшний үзлэг шалгалт хийх;</li> <li>✓ HBS-бүртгэгдсэн тээшний үзлэг шалгалт хийх;</li> <li>✓ Карго, ачаа тээш, шуудан илгээмжийн үзлэг шалгалт хийх.</li> </ul> <p>Хязгаарласан хориглосон эд зүйлсийн рентген зураг дээр тайлбарлах Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл;</li> <li>✓ Хурц ирмэгтэй зүйлс;</li> <li>✓ Шингэн зүйлс;</li> <li>✓ Сум ,галт хэрэгсэл;</li> <li>✓ Аюултай бараа;</li> <li>✓ Тусгай хэрэгсэл;</li> <li>✓ Иргүй мохоо багаж хэрэгсэл;</li> <li>✓ Зодооны хэрэгсэл, тоноглол;</li> <li>✓ Ажлын багаж хэрэгсэл;</li> <li>✓ Бусад хорiotой эд зүйлс;</li> </ul>	<p>Багшийн зааварчилгаагаар баг болон хуваарилагдана.</p> <p>Үзлэг шалгалт хийх үеийн туршлагаасаа ярилцана.</p>	5 мин	<p>Багийн гишүүд бүгд идэвхтэй оролцох, асуултад багаараа ажиллаж хариулах</p> <p>Сэдвээс өөр зүйл ярихгүй байх.</p>
4	Шинэ мэдлэг эзэмшүүлэх ТШУ 1.2		45 мин	

	Стандарт тест дээр ажиллуулах.	Багийн зааварчилгааг дагах	390 мин	
5	Суралцагчдын асуултад хариулах.	Ойлгомжгүй, тодруулах зүйлүүдийг багшаас асуух	25 мин	Суралцагчдын ойлгоогүй зүйлийг багш слайдаар харуулах, тайлбарлах.
6	Тоног төхөөрөмжийг ашиглан үзлэг хийх үед анхаарах зүйлсийг тайлбарлах. Дүрс дээр ажилласан тестийг программ хангамж дээр дүгнэх, алдсан дүрсийг график дээр тайлбарлах Нийт үзсэн хичээлийн талаар үнэлэлт дүгнэлт хийж, суралцагч нар ямар мэдлэг авсан талаар 1-2 өгүүлбэрт багтаан дүгнэн хэлэх.	Суралцагч ажилласан тестийн гүйцэтгэлийн тоймтой танилцах	20 мин	
<b>Нийт цаг</b>				<b>15 цаг</b>